

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

Хэнтий аймгийн иргэдээс авсан хэрэглэгчийн үнэлгээг нэгтгэн

дүгнэсэн тухай илтгэх хуудас

Монгол улсын Засгийн газрын 11-р тогтоолоор батлагдсан “Аймаг нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу Хэнтий аймгийн бүх сум, хот тосгоны ЗДТГ, ЗАА-наас ажлын хэсэг томилогдон үнэлгээний хуудсаар иргэдээс санал асуулга авч дүнг ирүүлснийг нэгтгэн боловсруулав. Уг санал асуулгад Хэнтий аймгийн хэмжээнд нийт 1720 иргэн хамрагдсан нь хөдөлмөрийн насны хүн амын 7,2%-ийг эзэлж байна. Санал асуулгыг явуулахдаа хүн амын нас, хүйс, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харгалзан нийгмийн бүлэг бүрийн төлөөллийг жигд хамруулахыг зорьж сум бүрт хүн амын 5-аас доошгүй хувийг санал асуулгад хамруулсан байна.

Иргэдээс авсан санал асуулгын дүнгээс үзэхэд,

1. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн талаар:
 - Бүрэн хангалттай – 5,7%
 - Хангалттай – 21,9%
 - Төдийлөн хангалттай биш – 36,8%
 - Хангалтгүй -20,3%
 - Мэдэхгүй – 12% буюу судалгаанд оролцогчдын 64,4% нь эерэг,
2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар:
 - Бүрэн хангалттай – 8,7%
 - Хангалттай – 23,4%
 - Төдийлөн хангалттай биш – 24,8%
 - Хангалтгүй – 21,5%
 - Мэдэхгүй – 19% буюу судалгаанд оролцогчдын 56,9% нь эерэг,
3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар:
 - Бүрэн хангалттай – 4,7%
 - Хангалттай – 27%
 - Төдийлөн хангалттай биш – 30,5%
 - Хангалтгүй – 18,3%
 - Мэдэхгүй – 22,2% буюу судалгаанд оролцогчдын 62,2% нь эерэг,
4. Төрийн үйлчилгээний талаар:
 - Бүрэн хангалттай – 11,8%
 - Хангалттай – 31,7%
 - Төдийлөн хангалттай биш – 26,8%
 - Хангалтгүй – 19,4%
 - Мэдэхгүй – 8,3% буюу судалгаанд оролцогчдын 70,3% нь эерэг хандлагатай үнэлгээ өгсөн байна.

Санал асуулгын бүрэн хангалттай, хангалттай, төдийлөн хангалттай биш гэсэн үнэлгээг эерэг хандлагатай гэж тооцсон бөгөөд энэхүү санал асуулгад оролцсон 1720 иргэний 63,5% нь төрийн ажил үйлчилгээнд эерэг үнэлгээ өгч 3,2 оноотой гарлаа. Гэлээ ч санал асуулгын дүнд дүгнэлт хийж хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг сурталчлах, иргэдэд тайлагнах ажлыг эрчимжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

ДАРГА

А.ГАНТӨМӨР

